

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2009 ОН

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЯМРАЛЫН ШАЛТГААН, НӨЛӨӨЛЛИЙГ ТОГТООХ, ХЯМРАЛААС ГАРАХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Судалгааны код: СТ-09/101
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ц.Батдорж, Ц.Батбаяр, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.02.09
Сэдвийн агуулга: Судалгаа нь үндсэн гурван бүлэгтэй ба (1) Монгол Улсын эдийн засаг санхүүгийн хямралын гадаад орчны нөлөө гэсэн эхний бүлэгт (а) дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралын уг сурвалж, учир шалтгаан, үйл явц, өрнөл, цаашдын хандлага, (б) хямралыг даван туулах талаар бусад орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн, (в) түүний Монгол Улсад үзүүлж буй нөлөөлөл, (г) сургамж, (д) зарим олон улсын байгууллагын зөвлөмж, (2) Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн дотоод орчин, төлөв байдал, цаашдын хандлага гэсэн хоёрдугаар бүлэгт (а) макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эдийн засгийн ерөнхий төлөв байдал, (б) төрийн санхүү, (в) төсвийн орлого, зарлагын байдал, (г) гадаад худалдаа, Засгийн газрын өр, (д) төрийн мөнгөний бодлого, (е) үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, бараа таваарын үнийн өсөлтийн шинжилгээ, инфляцийг бууруулах талаар Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, (ё) валютын зах зээл, (ж) санхүүгийн хямралтай холбогдуулан төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тус тус дэлгэрэнгүй багтаасан. Харин (3) гуравдугаар бүлэгт дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын Монгол Улсад үзүүлэх нөлөөллийг багасгах, хямралыг даван туулах чиглэлээр төр засгаас баримтлах бодлого, хэрэгжүүлж болохуйц арга хэмжээний санал, зөвлөмжийг багтаасан.

МОНГОЛ УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД: ЭРХ ЗҮЙ, ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/103
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Ариунаа, Ц.Батбаяр, Ч.Онончимэг, Б.Цолмонбаяр
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.04.13
Сэдвийн агуулга: Судалгаанд Монгол Улсын валютын зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, эрх зүйн орчин болон гадаадын зарим орны валютын зах зээлийн өнөөгийн байдал, нийтлэг асуудлууд, туршлага, сургамж зэргийг хамруулан судалсан.

МОНГОЛ УЛСАД ИПОТЕКЭЭР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/108
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Ариунаа, Ц.Батбаяр, Ч.Онончимэг, Ш.Хишигсүрэн, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.06.15
Сэдвийн агуулга: Монгол Улсын Засгийн газраас УИХ-д Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслүүдийг өргөн барьсантай холбогдуулан Монгол Улсад орон сууцны санхүүжилтийн зах зээл, түүнд оролцогч субъектүүдийн харилцааг зохицуулахаар санал болгож буй дээрх хуулиудын төсөлд шинжилгээ хийв.

Ипотекийн үнэт цаасны зах зээлийн ажиллах механизм, зохицуулалтын хувьд нарийн төвөгтэй, эрсдэлтэй зах зээлд тооцогддог. Энэ асуудлыг УИХ-аар хэлэлцэхэд тооцоо судалгаа, бодитой үнэлгээ, мэдээлэл, гарын авлага шаардлагатай учраас тус төвийн санаачилгаар энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэв. Сэдвийн хүрээнд бусад орнуудын туршлага, ипотекийн санхүүжилтийн зах зээлийн олон улсын стандарт загваруудыг харьцуулан судалсан.

2009 ОНЫ ТӨСӨВ БОЛОН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСЛИЙН ЗҮЙЛ АНГИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ, ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ХЭЛБЭР, БАРИМТЛАХ СТАНДАРТ ТУРШЛАГА, ЗАРИМ САНАЛУУД

Судалгааны код: СТ-09/205
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, А.Пагма, Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Занданшатар
Огноо: 2009.02.23
Сэдвийн агуулга: Төсвийн орлого буурч, зарлага нэмэгдэх тохиолдолд төсвийн тодотголыг хийх нь зайлшгүй бөгөөд энэ үед аливаа улс орны Засгийн газар төсвийн тодотголын стандарт хэрэгслүүдийг ашигладаг байна. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас улс оронд учирсан нөхцөл байдлууд болон санхүү эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс үүдэн улс орнууд төсвийн тодотголыг зайлшгүй хийх хэрэгтэй болдог. Судалгаанд Монгол Улсын 2009 оны төсөв болон төсвийн тодотголын орлого, зарлагын харьцуулалт, 2009 оны төсвийн тодотголтой холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн барьсан хуулиудын харьцуулсан бөгөөд төсвийн орлогыг нэмэгдүүлж, зарлагыг бууруулах талаар баримталж болохуйц Олон улсын стандарт арга туршлага, Улсын Төсвийн захирагч нарын Үндэсний холбоо (NASBO)-с гаргасан зөвлөмжийг багтаасан.

ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ БОДЛОГО, ӨРСӨЛДӨӨНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЯВЦ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-09/206
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.05.11
Сэдвийн агуулга: Судалгаанд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн болон шинээр боловсруулсан Өрсөлдөөний тухай хуулийн төслийн гол ялгаа, үзэл баримтлал, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, тэдгээрийг бусад улс орнуудын ижил төстэй хууль тогтоомжуудтай харьцуулсан байдлыг танилцуулна.

Өрсөлдөөний бодлогоо бусад улс орнуудад (БНХАУ, Тайвань, ОХУ, Украин, Беларусь, БНСУ, БНУУ) Өрсөлдөөнийг хамгаалах хууль, Монополийн эсрэг хууль, Шударга Худалдааны тухай хууль гэх мэт холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг ямар байгууллага хариуцдаг,

эдгээр байгууллагуудын статус, үйл ажиллагааны чиг хүрээ, эрх үүргийг онцолж өгөхийг зорьсон.

Мөн иргэд олон нийт, ТББ, эрдэмтэн судлаачдын зүгээс манай улсын өрсөлдөөний орчин, үнэ тариф, хэрэглэгчдийн эрх ашиг, шударга бус өрсөлдөөнийг хориглох хууль тогтоомжийн биелэлт, сайжруулах санал хувилбарууд зэргийг нийтэлсэн өдөр тутмын тогтмол хэвлэл мэдээллийн (2007, 2008, 2009.1-р улирал) нийтлэлд агуулгын дүн шинжилгээ хийж, өрсөлдөөний асуудлын талаар олон нийтийн санаа бодлыг нэгтгэн дүгнэв.

ЗАРИМ ОРНЫ ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО, БҮРТГЭЛИЙН СИСТЕМ, ХАРИУЦЛАГЫН СИСТЕМ

Судалгааны код: СТ-09/211
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Түвшинзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Балдан-Очир
Огноо: 2009.07.15
Сэдвийн агуулга: Судалгаанд Эстон, БНХАУ, Их Британийн хувь хүний орлогын албан татварын (1) тогтолцоо, (2) татвар ногдох орлого, (3) хувь хэмжээ, (4) татварын чөлөөлөлт, хөнгөлөлт, (5) бүртгэлийн систем, (6) хариуцлагын механизм зэргийн хамруулсан болно.

ТӨСВИЙН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХАРИЛЦАА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-09/214
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Ариунаа, Ц.Батбаяр, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Болормаа, Ч.Онончимэг, А.Пагма, Ц.Товуусүрэн, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2009.11.05
Сэдвийн агуулга: Судалгааны явцад дараах асуудлуудыг судалсан болно. Үүнд:
1. Монгол Улсын төсвийн харилцааны зохицуулалт, процесс, үе шат
2. УИХ-ын харьяа болон Засгийн газраас хараат бус байгууллагуудын төсөв, санхүүгийн харилцаа, бие даасан байдлыг хангах асуудлыг холбогдох салбарын хуулиар зохицуулсан байдал, өнөөгийн мөрдөж буй төсвийн эрх зүйн орчин
3. АНУ, Канад, Шинэ Зеланд, ОХУ, Украин зэрэг орнуудын төсвийн харилцаа, зохион байгуулалт, онцлох туршлага
4. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, түүнд өгөх санал.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ (2009 оны 1-р улирал)

Судалгааны код: СТ-09/308
Судалгааны төрөл: Тойм мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Сэдвийн агуулга: 2009 оны 1-р улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд болох төсөв, мөнгөний бодлого, гадаад худалдааны төлбөрийн тэнцэл, валютын ханш, валютын нөөц, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар, хэрэглээний үнийн индекс, нийгмийн салбарын зарим үзүүлэлтүүдийг тоймлон авч мэдээлэл бэлтгэсэн.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ (2009 оны 1, 2-р сар)

Судалгааны код: СТ-09/308
Судалгааны төрөл: Тойм мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Н.Цолмонбаяр
Захиалагч: 2009 оны эхний 2 сарын байдлаар улс орнуудын эдийн засагт хямрал үүсч, эдийн засгийн уналт бий болж, ажилгүйдэл газар авч байна. Дэлхийн улс орнууд хямралтай тэмцэх арга хэмжээнүүдийг нэгдсэн болон бие даасан байдлаар явуулж байна. Өнгөрсөн оны 12-р сард Канадын Төв банк бодлогын хүүгээ 1.5 хувь болгон бууруулж тус улс эдийн засгийн уналтанд ороод байгаагаа зарласан байна. 2009 оны 1-р сарын 22-нд АНУ-ын хамгийн том дөрвөн банк сүүлийн 20 хоногийн дотор үнэ цэнээ 50 хувь алдаж, энэ Даваа гаригийг “цэнхэр” Даваа гариг хэмээн нэрлэв. 2008 оны 9-р сараас хойш Хятадын төв банк бодлогын хүүгээ 4 удаа бууруулж, 5.31 хувь болгоод байна.

МОНГОЛ УЛСЫН (2009.09.01) БОЛОН ДЭЛХИЙН (2009.10.01) ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Судалгааны код: СТ-09/311
Судалгааны төрөл: Тойм мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ц.Батдорж, Ц.Батбаяр, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа, Б.Цолмонбаяр
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Сэдвийн агуулга: Тойм мэдээнд Монгол Улсын төсөв, мөнгөний бодлого, гадаад худалдааны тэнцэл, валютын ханш, валютын нөөц, аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийн талаарх асуудлуудыг тоймлон авч баримт бичгийн харьцуулалтын аргыг хэрэглэн энэхүү мэдээллийг бэлтгэн гаргалаа.

ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТӨВ БАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ

Судалгааны код: СТ-09/401
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Батбаяр
Сэдвийн агуулга: Төв Банкуудаас Японы Төв Банкны бодлогын хүү хамгийн бага нь буюу 0.5 хувиас 0.1 хувь болгон бууруулсан байна. Дэлхийн томоохон зургаан Төв Банк 2008.10.08-ны Лхагва гаригт зэрэг хүүгээ буулгасны маргааш буюу Пүрэв гаригт Азийн зарим томоохон орнуудын Төв Банкууд бодлогын хүүгээ бууруулсан байна. Зарим Төв банкуудын зүгээс бодлогын хүүгийн таамаглалыг олон нийтэд зарлах нь зах зээлийн үйл ажиллагааг гажуудуулах сөрөг талтай гэж үзэж байна. Энэ асуудлаар BIS (Bank for International Settlement) буюу Олон Улсын Төв Банкны эдийн засагчид судалгаа хийсэн ба үүнд Төв банкуудын бодлогын хүүний тухай олон нийтэд өгч буй мэдээлэл нь санхүүгийн зах зээлийг гажуудуулж буй эсэхийг судлах зорилгоор АНУ, Еврогийн бүс болон Шинэ Зеландын зах зээлийн төлөв байдлыг судалж холбогдох дүгнэлтүүдийг хийсэн байна.

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ХЯМРАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН ТӨСВИЙН ТАЛААР ЗАРИМ (ПОСТСОЦИАЛИСТ) ОРНУУДЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ЗАСГИЙН ГАЗРААС УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН ТӨСВИЙН ТОДОТГОЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЗАРИМ ТББ-ЫН ГАРГАСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны код: СТ-09/408
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Ариунаа, Г.Билгээ, Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Батбаяр
Сэдвийн агуулга: Мэдээлэл лавлагаанд төсвийн тодотголтой холбоотой Засгийн газрын болон ТББ-уудын саналыг харьцуулахын зэрэгцээ Унгар, Орос, Казахстан, Латви, Украин зэрэг орнуудын Засгийн газраас улсын төсвийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг авч судалсан болно.

2010 ОН

УУЛ УУРХАЙН ОРЛОГООС ИРГЭДЭД МӨНГӨ ТАРААХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЗЭРЭГ СӨРӨГ ҮР ДАГАВАРЫН ТООЦООЛОЛ

Судалгааны код: СТ-10/103
Судалгааны төрөл: Бодлогын судалгаа
Судалгааг удирдсан: Ц.Норовдондог (Ph.D)
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Батсүх /Ph.D/, Д.Ариунаа/MSc/, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн З.Алтай, Г.Баярсайхан, С.Оюун, Д.Энхбат
Огноо: 2010.02.04
Сэдвийн агуулга: Судалгааны гол зорилго нь стратегийн ашигт малтмалын ордуудаас ойрын жилүүдэд Хүний хөгжил санд төвлөрөх боломжтой хэмээн үзсэн хөрөнгийн эх үүсвэр нь Монгол Улсын иргэн бүрд 1,5 сая төгрөгийг бэлэн ба бэлэн бус хэлбэрээр олгоход хүрэлцэх эсэх, дутагдах хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ болон 1,5 сая төгрөгийг олгох боломжит хувилбаруудыг үнэлэхэд оршино. Судалгааны ажлын үр дүн нь 1,5 сая төгрөгийг иргэдэд бэлэн болон бэлэн бусаар тараахад түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хувилбар тус бүрээр тооцож дээрх хувилбарууд нь өрхийн орлого зарлагын загвар болон макро эдийн засгийн индикаторуудад хэрхэн нөлөөлөх нөлөөллийг тооцоход чиглэгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/202
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Судалгааг удирдсан: Ц.Норовдондог (Ph.D)
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа /MSc/, Ц.Батбаяр, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв
Огноо: 2010.01.13
Сэдвийн агуулга: Энэ судалгааны нэгдүгээр бүлэгт: Хөрөнгийн үнэлгээний талаарх ерөнхий ойлголт, Монгол Улсын хөрөнгийн үнэлгээний системийн өнөөгийн байдал, хөрөнгийн үнэлгээний эдийн засгийн болон эрх зүйн орчны талаар судлав.
Хоёрдугаар бүлэгт: УИХ-д өргөн баригдсан хөрөнгийн үнэлгээний хуулийн төсөлд шинжилгээ хийж, хуулийн төслийн заалт хоорондын уялдаа болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдсан талаар судлав.
Гуравдугаар бүлэгт: ОХУ-ын болон Украин Улсын Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг УИХ-д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөлтэй харьцуулан дүгнэлт гаргасан бөгөөд мөн АНУ, Их Британи, ОХУ, Украин, Израиль зэрэг улс орны үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын талаар товч мэдээллийг гарган хүргүүлэв.

ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/209
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Загджав
Огноо: 2010.05.05
Сэдвийн агуулга: Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 1-д “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” хэмээн хуульчлан тогтоосон. Харин Нэгдмэл улсын нутаг дэвсгэрийн засаг захиргаанд нь эрх зүйн хэм хэмжээг бие даан дангаараа тогтоох бүрэн эрх байдаггүй тул тэдгээр нь засаг захиргааны төв байгууллагуудад, үүний дотор татварын асуудлаар захирагддаг байна.

Дээр нь орон нутгийн татварын асуудал нь шилжилтийн улс оронд чухал ач холбогдолтой байгаа учраас Болгар, Польш, Солонгос зэрэг улсуудыг сонгон тэдгээрийн орон нутгийн татварын эрх зүйн харилцааг зохицуулж байдаг бие даасан хуулиудыг судалж үзсэн.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/211
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Ц.Батдорж
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Загджав
Огноо: 2010.05.20
Сэдвийн агуулга: Энэхүү судалгааны зорилго нь орон нутгийн төсвийн бие эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбогдуулан одоо мөрдөгдөж байгаа хуулиудын эерэг сөрөг талуудыг гарган бусад орны бие даасан хуулиудтай харьцуулан судалж дүгнэлт гаргахад оршино. Судалгаанд орон нутгийн төсвийн талаарх онолын үндэслэл, Монгол Улсын орон нутгийн төсвийн харилцааны өнөөгийн байдал эерэг болон сул талууд, Орон нутгийн төсвийн харилцааны талаарх бусад орны туршлагыг судалсан.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-10/213
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2010.05.19
Сэдвийн агуулга: Судалгаанд Монгол дахь ХЗХ-дын талаарх тойм мэдээлэл, тухайлбал, эрх зүйн зохицуулалт, хяналтын орчин, ХЗХ-дын үйл ажиллагаанд тулгарсан асуудлууд, өнөөгийн байдал болон УИХ-д өргөн бариад байгаа ХЗХ-ны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн бүтэц, агуулгын талаар тоймлосон.

WOCCU буюу Дэлхийн хадгаламж, зээлийн хоршооны зөвлөл (ДХЗХЗ) нь олон улсын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулдаг банк бус салбарыг хөгжүүлэх зорилготой байгууллага бөгөөд дэлхийн 84 орны 123 сая иргэдэд үйлчилгээ үзүүлдэг 40 мянга гаруй хоршоо, холбоодыг гишүүн болгон эгнээндээ элсүүлээд байна. ДХЗХЗ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулдаг хоршоодыг судалж, 100 гаруй орны холбогдох хуульд үнэлгээ хийж, бүс нутаг, улс орны хадгаламж, зээлийн холбоодын

нэн тохиромжтой гэх саналуудыг хүлээн авч түүнд тулгуурлаж ХЗХ-ны тухай загвар хуулийг боловсруулсныг судалгаанд оруулсан.

Түүнчлэн гадаад орнуудын (Чех, Узбекистан, Литва, Эстони, Их Британи, Хонконг, Шинэ Зеланд, АНУ) ХЗХ-ны тухай хуулийн зарим зохицуулалтыг харьцуулж оруулсан.

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТӨСӨВ, МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ДИНАМИК СУДАЛГАА

Судалгааны код: СТ-10/301
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Судалгааг удирдсан: Ц.Норовдондог (Ph.D)
Гүйцэтгэсэн судлаачид: Д.Ариунаа/MSc/, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа, Ц.Батдорж, Г.Билгээ
Захиалгач: УИХ-ын гишүүн З.Алтай, Г.Баярсайхан, С.Оюун, Д.Энхбат
Огноо: 2010.02.08
Сэдвийн агуулга: “Хүний хөгжил сан”-гийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Монгол Улсын иргэдэд мөнгө тараах эдийн засгийн нөөц боломж бий эсэх асуудлыг тодруулах зорилгоор макро эдийн засаг, төсөв, санхүүгийн өнөөгийн байдал, сүүлийн 5 жилийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулан судлахад чиглэгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ХУДАЛДААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ХӨРШ ОРНУУДАЙ ХИЙСЭН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ХӨТӨЛБӨРҮҮД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ: ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-10/302
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Ариунаа, Ц.Батбаяр, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Ч.Улаан
Огноо: 2010.03.29
Сэдвийн агуулга: Монгол Улсын гадаад худалдааны хөгжил, гадаад худалдааны тулгамдсан асуудлууд, хөрш орнуудтай хийж буй худалдаа, эдийн засгийн харилцаа, гадаад худалдааны эрх зүйн орчны тухай тойм судалгааг дараахь бүтэцтэйгээр хийж гүйцэтгэлээ. Нэгдүгээр хэсэгт, дэлхийн худалдааны байдлын тухай ерөнхий тойм, дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямралын худалдаанд үзүүлсэн үр нөлөө, худалдааны бүтэц, өөрчлөлтийн талаар, хоёрдугаар хэсэгт, Монгол Улсын худалдааны бодлогыг зохицуулж буй хууль эрх зүйн орчны шинжилгээ, худалдааны чөлөөт бүсүүдийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, Монгол Улсаас ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудын биелэлтийн тухай мэдээллүүдийг тус тус орууллаа.

Дараагийн хэсгүүдэд, Монгол Улсын гадаад худалдааны бодлого, түүнийг хэрэгжүүлэгч субъектүүд, гадаад худалдааны өнөөгийн байдал, гадаад худалдааны хөгжил, хөрш орнуудтай хийсэн худалдаа, баримталж буй бодлого, экспорт импортын бүтэц, гадаад худалдааны тэнцлийн динамик зэрэг мэдээллийг тоймлон хүргүүлж байна.

Эцэст нь, гадаад худалдааны бодлогоор дамжуулан эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар улс орнуудын засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэх боломжтой бодлогын арга хэмжээ, гадаад худалдааны эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой санал дүгнэлтүүдийг орууллаа.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЗАРИМ ХУУЛИУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

<i>Судалгааны код:</i>	СТ-10/412
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Судалгааг удирдсан:</i>	Ц.Норовдондог /Ph.D/
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Батбаяр, Ц.Батдорж, Б.Буяндэлгэр, Г.Билгээ, Т.Мягмаржав, Д.Мягмарцэрэн, Б.Мөнхцэцэг, О.Нарантуяа, Ч.Онончимэг, А.Пагма, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын даргын зөвлөх С.Банзрагч
<i>Огноо:</i>	2010.03.29
<i>Сэдвийн агуулга:</i>	Монгол Улсын эдийн засгийн харилцааг зохицуулж буй зарим хуулиудын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, дүн шинжилгээ хийсэн. Үүнд: Монгол Улсын төсвийн тухай хуулиуд, Татварын холбоотой зарим хуулиуд, Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд, Валютын арилжаа, гадаад худалдаа, зээл тусламжийн талаар холбоотой хуулиуд, Компани, аж ахуйн нэгж, хоршооны талаар холбоотой хуулиуд, Ашигт малтмалын талаар холбогдох хуулиуд, Монгол Улсыг хөгжүүлэх сан болон бусад сангийн үйл ажиллагааны талаар холбоотой хуулиуд, Эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын талаар холбоотой хуулиуд, Аудитын /хяналт шалгалт/ талаар, Эдийн засгийн харилцааг зохицуулж буй бусад хуулиуд багтсан байна.

2011 ОН

МОНГОЛ УЛСЫН 2011 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙ МАКРО ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-11/101
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Болормаа, Ц.Батдорж, Г.Билгээ, Г.Гэрэл, Д.Мягмарцэрэн, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Н.Ганбямба
<i>Огноо:</i>	2011.03.02
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү судалгаагаар 2000-2010 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн ерөнхий танилцуулга, макро эдийн засгийн өсөлт, бууралт, инфляци болон ажилгүйдэл ямар түвшинд ирсэнийг тооцохын зэрэгцээ 2011 оны Нэгдсэн төсөв үүнд хэрхэн нөлөөлж болзошгүй талаарх таамаглалыг дэвшүүлсэн болно. Судалгааны ажлыг хийж гүйцэтгэн эдийн засгийн өсөлтийн хувийг тооцохдоо 2000-2010 оны статистик тоон мэдээлэл, 2011 онд батлагдсан Монгол Улсын төсөв болон бусад судалгааны тайлан мэдээллийг ашиглан, 2011 оны батлагдсан төсөв нь Монгол Улсын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлөхийг эконометрикийн коинтэгрэшн болон регрессийн шинжилгээний аргаар судалсан болно.

ТӨСВИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ПАРЛАМЕНТ ДАХ БҮТЦИЙН НЭГЖҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-11/209
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Г.Билгээ, Г.Гэрэл, О.Нарантуяа, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Огноо: 2011.03.31
Сэдвийн агуулга: Энэхүү судалгаагаар АНУ, Солонгос, Канад, Гүрж зэрэг орны парламентын төсвийн судалгааны алба, Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Канад зэрэг орны Төрийн хариуцлагын хороо болон Монгол Улсын нэгдсэн төсөв болосвруулах, батлах, хэрэгжүүлэх үе шатуудад оролцох төрийн байгууллагуудын чиг үүргийн талаар судалсан.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, парламентыг төсвийн талаарх хараат бус мэдээлэл, шинжилгээгээр хангах бие даасан нэгж байгуулах энэ асуудлыг шийджээ. Тухайлбал, Бельги, Канад, Унгар, Солонгос, Нидерландад PBO (Parliamentary Budget office)-100 орчим хүнтэй, эсвэл Австри, Шведэд Fiscal Council, АНУ-д CBO (Congressional budget office)-235 хүнтэй гэх мэтээр нэрлэдэг, нэлээд томоохон бүтэцтэй нэгж бие даан ажилладаг байна. Энд макро эдийн засгийн шинжээч, татварын шинжээч, төсвийн шинжээч, Засгийн газар хариуцсан шинжээч, тойрог хариуцсан шинжээч, аналитик шинжээчид, программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан гэх мэтийн томоохон бүтэцтэй.

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БУЙ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ БОЛОН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-11/223
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Бямбацогт
Огноо: 2011.10.10
Сэдвийн агуулга: Судалгааны 1-р хэсэгт “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх үндэслэл, шаардлагыг уг хуулийн хувийн хэрэг дээр тулгуурлан судаллаа. 2-р хэсэгт 1993 оноос хойш мөрдөгдөж байсан “Улсын тэмдэгтийн тухай” хууль болон 2010 оны шинэчилсэн найруулга, 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зохицуулсан тэмдэгтийн хураамжийн төрөл, үйлчилгээний чиглэл тус бүрийн хураамжийн хэмжээний харьцуулалтыг гаргалаа.

НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛСЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРИМ ТӨРӨЛ

Судалгааны код: СТ-11/419
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц. Норовдондог (Ph.D), Г.Билгээ
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2011.10.26
Сэдвийн агуулга: Лавлагаа-мэдээлэлд Нидерландын Вант улсын орлогын албан татвар, аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар, цалингийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг албан татваруудын төрлүүдийн албан татвар төлөгч, ногдох орлого, хувь хэмжээ, хөнгөлөлт гэсэн дэд сэдвээр задласан. Мөн 2002.03.08-нд Монгол Улс, Нидерландийн Вант Улсын Засгийн газар хооронд Орлогын албан татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай конвенцийг байгуулсан ба уг конвенцийн талаар судалгааны 5-р хэсэгт оруулсан.

**МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ
ЗҮЙН АГУУЛГА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА БОЛОН ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
АРХИ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭЛБЭР, АРХИДАЛТТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА**

Судалгааны код: СТ-11/503
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ц.Батбаяр, Ц.Батдорж, Г.Билгээ, Г.Гэрэл, Ч.Онончимэг,
Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг, Д.Тэрбишдагва, УИХ-ын Тамгын газрын Эрх зүй
хууль, тогтоомжийн хэлтэс
Огноо: 2011.05.18
Сэдвийн агуулга: Уг дүн шинжилгээнд “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгыг хэлэлцэх үндэслэл, шаардлагыг уг хуулийн хувийн
хэрэг дээр тулгуурлан судалсан ба 1993 оноос хойш мөрдөгдөж байсан
хуулиудаар зохицуулсан тэмдэгтийн хураамжийн төрөл, үйлчилгээний
чиглэл тус бүрийн хураамжийн хэмжээний харьцуулалтыг гаргалаа.

**УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРИГДСАН ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2012 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааны код: СТ-11/506
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Ц.Элбэгзаяа, Б.Дуламсүрэн
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2011.11.04
Сэдвийн агуулга: Монгол банк 2008 оноос эхлэн инфляцийг онилох бодлого буюу инфляцийг
тогтвортой доогуур түвшинд барихад чиглэгдсэн бодлого явуулж ирсэн.
Инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэх нь инфляцийг бага түвшинд
тогтвортой барьж, улмаар ирээдүйн тодорхой бус байдлыг бууруулж өгдөг
давуу талтай хэдий ч, хэтэрхий их болгоомжлолоос болж эдийн засгийн
өсөлтийг хязгаарлаж, валютын ханшийг уян хатан нөхцөлд явуулахыг
шаарддаг учраас ханшийн тогтворгүй байдлыг ихэсгэж, санхүүгийн зах
зээлийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

2012 ОН

ДЭЛХИЙН БУСАД ОРНУУДЫН ТӨВ БАНК, ТЭДГЭЭРИЙН ХАРЬАЛАЛ, ЧИГ ҮҮРЭГ

Судалгааны код: СТ-12/203
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Г.Гэрэл,
Ч.Онончимэг
Захиалагч: Судалгааны төв
Огноо: 2012.03.02
Сэдвийн агуулга: Төв банкны талаарх ерөнхий ойлголт, үйл ажиллагаа, мөнгөний бодлого,
түүнийг яагаад Засгийн газраас хараат бусаар явуулдаг тухай болон ОХУ,
БНХАУ, АНУ, Англи, Канад, Япон, Норвегийн Вант Улс, Болгар, Польш,
Турк улсуудын Төв банкны тогтолцоо, үндсэн чиг үүрэг, банкны харьяалал
гэсэн агуулгатай болно.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БАРЬЦААЛСАН /МОРГЕЙЖ/ ЗЭЭЛИЙН ХҮҮ БА ҮНДСЭН НӨХЦӨЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/207
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2012.05.07
Сэдвийн агуулга: Дэлхийн бусад орнуудад иргэдийг орон сууцтай болоход нь зориулж моргейжийн зээлийг хүртээмжтэй, сонголттой олгох ямар схемийг ашигладаг, шаардагдах санхүүжилтыг хэрхэн бий болгодог, орлого багатай иргэдээ орон сууцтай болоход нь төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлдэг эсэх, ямар арга замаар хэрхэн дэмжлэг үзүүлдэг зэрэг асуудлуудыг тодруулахыг зорилоо. Үүний тулд үл хөдлөх хөрөнгийн зээлийн нөхцөл, хугацаа, хүү болон холбогдох бусад мэдээллийг харьцуулан авч үзсэн болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-12/226
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Билгээ, Д.Байгалмаа, Ц.Батдорж, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан, Д.Оюунхорол, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн
Огноо: 2012.11.06
Сэдвийн агуулга: Судалгаанд захиалгад ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг нийтлэг байдлаар зохицуулсан Вьетнам, Индонези, Казахстан, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг тусад нь салбар хуулиар зохицуулсан Бразиль, Чили, ОХУ зэрэг орнуудын туршлагыг авч үзэв. Гадаадын хөрөнгө оруулалтаар эдийн засгаа амжилттай хөгжүүлсэн туршлага бүхий орнууд, эдийн засгийн өсөлт, хөгжлөөр манай улстай ойролцоо улс орнууд гэсэн шалгуурыг үндэслэн судалгаанд хамрагдсан орнуудыг сонгосон болно.

Судалгаанд Монгол Улсын гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын талаарх тоон мэдээллийг 1990-2011 онуудын хооронд дахь тоон үзүүлэлтээр авч үзэн, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны нөхцөл, татварын орчныг одоо мөрдөж байгаа хууль, тогтоомжийн хүрээнд судалсан болно.

АНУ-ЫН ТӨСӨВ ЗОХИОХ, БАТЛАХ, ХУВИАРЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-12/305
Судалгааны төрөл: Тойм судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Б.Дуламсүрэн
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
Сэдвийн агуулга: Аливаа улсын төсөв гэдэг нь зөвхөн тодорхой хэмжээний хөрөнгийг төрийн мэдэлд хуримтлуулж зарцуулахдаа биш, тухайн улс орны хөгжлийн цаашдын урт хугацааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх гол хэрэгсэл байх ёстой. Энэ үүднээс манай улсын хувьд төсвийг үрэлгэн зардалд биш, бэлэнчлэх сэтгэлгээний нийгэмд биш, тодорхой бүтээн байгуулалт, үйлдвэрлэлд чиглүүлж улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэх үүднээс төсөв хэлэлцэх чадавхийг сайжруулахад анхаарч, төсвийн үйл явцад гадаад улс орнуудын “сайн” туршлагыг судлан үзэх нь чухал юм. Тус судалгаанд АНУ-ын Холбооны засгийн газрын төсвийн

харилцааны эрх зүйн зохицуулалт, төсөв зохиох, хянах, судалгаа дүгнэлт гаргах, батлах процессын талаар авч үзлээ.

ЗАРИМ ОРНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ХҮН АМЫН ОРЛОГЫН ТҮВШНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-12/401
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2012.05.07
Сэдвийн агуулга: Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу улс орныг түүвэрлэхдээ Дэлхийн банкнаас гаргасан “Улс орнуудын орлогын түвшингийн ангилал”-ыг гол шалгуур болгон авсан бөгөөд хөгжлийн түвшингийн хувьд ялгаатай улс орноос тус бүр таван орон сонгон холбогдох үзүүлэлтүүдийг харьцуулан судалсан болно.

Дэлхийн банкны судалгаанд өндөр орлоготой улсуудаас дээрх таван орны ядуурлын үзүүлэлт болон Жини индекс (орлогын тэгш бус хуваарилалт)-ийн үзүүлэлт сүүлийн оны байдлаар тодорхой тусгагдсан байсан тул энэхүү судалгаанд сонгон авлаа.

2008-2012 ОНУУДАД ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛД НИЙТЛЭГДСЭН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АСУУДЛААРХИ ЭДИЙН ЗАСАГЧИД, ЭРДЭМТЭН СУДЛААЧИД, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ШҮҮМЖ

Судалгааны код: СТ-12/405
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Гэрэл, Г.Билгээ, Б.Дуламсүрэн, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын дарга Д.Дэмбэрэл
Огноо: 2012.06.20
Сэдвийн агуулга: Хэвлэлийн контент анализийг гүйцэтгэхдээ 2008-2012 оны өдөр тутмын Өдрийн сонин, Ардын эрх, Өнөөдөр зэрэг сонин болон интернэт сайтууд дах мэдээллүүдээс макро эдийн засаг, төсөв мөнгөний талаар эдийн засгийн салбарын эрдэмтэд, судлаач, шинжээчдийн гаргасан санал, дүгнэлт, шүүмж, нийтлэл ярилцлагыг түүвэрлэн авч үзлээ. Уг судалгааг гүйцэтгэхдээ цуглуулсан мэдээллүүдийг нэгтгэн ангилж төсөв, мөнгөний үзүүлэлт, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд тухайн онуудад ямар түвшинд байсан, тэдгээрийг эдийн засагчид хэрхэн үнэлж дүгнэж байсныг тодруулан харуулахыг зорилгоо. Үүний тулд тухайлсан эрдэмтэд, судлаач бүрийн дүгнэлт, санал шүүмжүүдийг хавсралтанд дэлгэрэнгүй хүснэгт хэлбэрээр орууллаа. Мэдээллүүдээ цэгцтэй нэгдсэн хэлбэрт оруулах үүднээс олонхийн санал шүүмж, дүгнэлтийг хамарч чадсан голлох нийтлэлийг сонгон авч энэ хэсэгт тухайн он бүрээр нь ялган харуулав.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙН АСУУДАЛ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-12/501
Судалгааны төрөл: Дүн шинжилгээ
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Б.Дуламсүрэн, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Р.Гончигдорж
Огноо: 2012.02.06

Сэдвийн агуулга:

Судалгааны захиалгын дагуу төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн үзүүлэлт, төсвийн эрх мэдлийн хуваарилалт 1990 оноос хойш батлан хэрэгжүүлж буй төсвийн тухай хууль тогтоомжуудаар хэрхэн зохицуулагдаж ирсэнийг тухайн үед мөрдөж байсан болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжуудын концепци, мөн тоон судалгааны үзүүлэлтүүдэд тулгуурлан дараахь үечлэлээр дүн шинжилгээ хийв. Үүнд:

- “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хууль батлагдахаас өмнөх үед /1992-2002 он/
- “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хууль хэрэгжиж байсан үед /2002-2011/
- “Төсвийн тухай хууль” шинэчлэгдэн батлагдсанаас хойшхи үед /2011 оноос хойш/

Судалгааны зорилго нь төсвийн төвлөрлийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, одоо мөрдөгдөж байгаа болон өмнө нь хэрэгжиж байсан хуулиудын эерэг, сөрөг үр дагаварыг тоон болон чанарын судалгааны аргаар тодорхойлоход чиглэгдсэн болно.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БУЙ ТӨСВИЙН ТӨВЛӨРӨЛ, ЭС ТӨВЛӨРЛИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Судалгааны код:

СТ-12/503

Судалгааны төрөл:

Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач:

Ц.Норовдондог (Ph.D), Д.Мягмарцэрэн, Ц.Батдорж, Г.Билгээ, Ц.Болормаа, Б.Дуламсүрэн, Ч.Онончимэг

Захиалагч:

УИХ-ын гишүүн Р.Гончигдорж

Огноо:

2012.04.16

Сэдвийн агуулга:

Энэ удаагийн судалгааг өмнөх судалгаа /Монгол Улсын төсвийн харилцаан дахь төсвийн төвлөрлийн асуудал, төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн дүн шинжилгээ/-нд тулгуурлан 2011 онд шинэчлэн батласан Төсвийн тухай хуулиар зохицуулж буй төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн байдалд дүн шинжилгээг хийлээ. Улсын төсвийн төвлөрсөн, эс төвлөрсөн байдлыг илтгэдэг гол үзүүлэлтүүд ДНБ-д эзлэх орон нутгийн төсвийн орлого болон Улсын төсвийн орлогод орон нутгийн орлогын эзлэх хувь болохыг тодорхойлсон байдаг.

Иймээс судалгааг гүйцэтгэхдээ одоо мөрдөгдөж байгаа 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хууль болон 2013 оноос мөрдөгдөж эхлэх Төсвийн тухай хуулиудын улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын талаар холбогдох заалтуудыг харьцуулан авч үзлээ. Үүнд дээр үндэслэн Сангийн яамнаас гаргасан 2013-2015 оны төсвийн төсөөлөлийн тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

2013 ОН

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код:

СТ-12/227

Судалгааны төрөл:

Харьцуулсан судалгаа

Гүйцэтгэсэн судлаач:

Ц.Норовдондог, Г.Билгээ, Д.Байгалмаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг

Захиалагч:

УИХ-ын гишүүн, УИХ-ын ТБХ-ны дарга Ц.Даваасүрэн

Огноо: 2013.06.21
Сэдвийн агуулга: Судалгаанд АНУ, ХБНГУ, ОХУ, Япон болон Шинэ Зеланд зэрэг орнуудын төрийн эрх мэдэл хуваарилалт, шүүх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцооны онцлог мөн түүнчлэн эдгээр орнуудын төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, парламентаар хэлэлцэн батлах, тайлагнах процессын талаар судалсан болно.

НЭМЭГДСЭН ӨРТӨГИЙН АЛБАН ТАТВАР БА ХУДАЛДААНЫ ТАТВАРЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/231
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүд Г.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар
Огноо: 2013.09.19.
Сэдвийн агуулга: Гадаадын зарим орны Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан судалсан болно. Мөн судалгааны явцад Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хоорондын ялгаатай ойлголт, онолын тайлбар болон олон улсын чиг хандлагын талаарх асуудлыг хамтатган авч үзэв.

ДЭЛХИЙД ХӨГЖЛӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЭГЧ ЗАРИМ ОРНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА, ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/239
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Б.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Бямбацогт
Огноо: 2013.11.15
Сэдвийн агуулга: Дэлхий дахинд хөгжлөөрөө тэргүүлэгч, хөгжлийн тогтвортой, тодорхой бодлого хэрэгжүүлдэг зарим орнуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онцлог, арга туршлага болон бодлого боловсруулахад баримталдаг зарчим, бодлогын хоорондын уялдаа холбоо, амжилтад хүрсэн туршлага, ирээдүйн хөгжлийн төлөвлөлт болон төсөөллийн талаарх асуудлыг хамруулсан. Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Швейцар, Их Британи, Япон, Өмнөд Солонгос, Хятад, Орос, Малайз улсуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн туршлагыг судалсан болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/242
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог (доктор), Г.Алтан-Оч (доктор), Д.Байгалмаа (магистр), Г.Билгээ (магистр), Ц.Болормаа (магистр), Ч.Онончимэг (магистр), Ц.Элбэгзаяа (магистрант)
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.12.12
Сэдвийн агуулга: Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн холбогдолтой практикт зөрчил үүсгэж буй тодорхой асуудлуудыг бусад орнуудын хууль тогтоомжоор хэрхэн зохицуулсан, олон улсад баримталдаг зохицуулалтын нийтлэг стандарт нь ямар байдаг, судлаачид, мэргэжлийн хүмүүс хэрхэн үзэж байгаа талаар судалгааны мэдээллийн хайлт хийж, олдсон

мэдээллийн хүрээнд асуудлыг тодруулан гаргах, захиалагчид тодорхой мэдлэг, ойлголт өгөхөд чиглэгдсэн болно. Судалгаанд:

- Олон улсын хөгжлийн агентлаг (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын зохицуулалтын олон улсын зарчим ба хэрэгжүүлэх механизм”
- Үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо (IOSCO)-ноос баталсан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим, хэрэгжүүлэх механизм”
- Бусад орнуудын Хувьцаат компанийн үйл ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн актуудыг судалж, олдсон мэдээллийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тодруулан гаргах (АНУ, Англи, ОХУ, Турк, Герман улс).

ТҮРЭЭСИЙН ТАТВАРЫН ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/243
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Н.Батцэрэг
<i>Огноо:</i>	2013.12.25
<i>Сэдвийн агуулга:</i>	Монгол Улс болон гадаадын зарим улс оронд баримталж буй түрээсийн татварын бодлого, холбогдох эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг хийсэн бөгөөд Монгол Улсын иргэний хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон АНУ, Ирланд, БНСУ, Малайз, Кени, Канад зэрэг улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/414
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ж.Батзандан
<i>Огноо:</i>	2013.07.08
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд Их Британи, Нидерланд, ОХУ, Украин, болон БНХАУ-ын Хүн амын орлогын албан татварын эрх зүйн зохицуулалт, албан татварын хувь, хэмжээ болон татварын буцаан олголтын тогтолцоо, зохицуулалтын талаар авч үзсэн болно.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/415
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ж.Батзандан
<i>Огноо:</i>	2013.07.08
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд Индонез, Казахстан, Нидерланд, ОХУ, Чили болон БНХАУ-ын НӨАТ-ын эрх зүйн зохицуулалт, албан татварын хувь, хэмжээ болон НӨАТ-ын буцаан олголтын эрх зүйн зохицуулалтын талаар авч үзсэн болно.

ЗАРИМ ОРНУУДЫН НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА ЦАЛИНГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦАА, ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-13/503

Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Гэрэл, Ч.Онончимэг

Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг

Огноо: 2013.02.22

Сэдвийн агуулга: Судалгаанд дэлхийн 72 орны эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ болон цалин хөлсний дундаж үзүүлэлтийн талаарх лавлагаа мэдээлэл гаргаснаас гадна хөгжлийн түвшингээр ялгаатай 18 орныг сонгон эдгээр үзүүлэлтүүдийн хоорондын харьцаа, уялдааг холбоог эдийн засгийн эконометрик шинжилгээний аргаар тооцоолж, уялдаа холбоог авч үзэн дүн шинжилгээ хийсэн.